



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Г Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10, 5.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчөөс шилжүүлсэн 361,005,573.00 (гурван зуун жаран нэгэн сая таван мянга таван зуун далан гурав) төгрөгийн балансын үнэ, 153,427,368.78 (нэг зуун тавин гурван сая дөрвөн зуун хорин долоон мянга гурван зуун жаран найман төгрөг далан найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Онцгой байдлын өрөнхий газрын харьяа Дорноговь аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын өрөнхий газрын дарга Бригадын генерал Г.Ариунбуян, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга М.Баяраа, Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын дарга Г.Бат-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээлцэж, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2021 оны 07 дугаар сарын 08.дэдрийн
30.....дугаар тогтоолын хавсралт

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид хүлээн авч Дорноговь аймгийн Онцгой байдлын газарт
эзэмшилж бүртгэх хөрөнгө

Д/А	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ /төгрөг/	Хурийтлагдсан элдэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	"Хово синотрак" маркийн улсын дугаар 23-10 БРА, арлын дугаар 1 LZZWBYVF0GW1449158 /Ой хээрийн түймэр унтраах тусгай зориулалтын автомашин/	2016	1	361,005,573.00	153,427,368.78	207,578,204.22
	Нийт дүн			361,005,573.00	153,427,368.78	207,578,204.22